



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СҮМҮН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар №20

Бор-Өндөр

Г Хөрөнгө бүртгэх тухай Г

Боловсролын өрөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Хэний аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Анги бүлгүүдийн эцэг эхийн хандиваар авсан 26,513,000 (хорин зургаан сая таван зуун арван гурван мянга) төгрөгийн балансын үнэтэй хавсралтад дурдсан үндсэн хөрөнгө, 1,349,000 (нэг сая гурван зуун дөчин есөн мянга) төгрөгийн балансын үнэтэй хавсралтад дурдсан эргэлтийн хөрөнгийг тус тус орлого авч, данс бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад дурдсан үндсэн хөрөнгийг холбогдох дүрэм журам, хууль тогтоомжийн дагуу орлого авч, данс бүртгэлд бүртгэхийг нягтлан бодогч (Б.Анхчимэг), үндсэн хөрөнгийг бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг нярав (Ц.Туяацэцэг), өмч хамгаалах байнгын зөвлөл (Х.Хулан) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРЖАРГАЛ

